



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1171

Шивээговь сум

“Цагдаагийн эргүүлийн машин” худалдан  
авах ажлын барааг хүлээн авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн “Цагдаагийн эргүүлийн машин” худалдан авах ажлын барааг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Халиун

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Б.Шинэбаяр

(Сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч)

Ё.Батцэнгэл

(1 дүгээр багийн иргэн)

2. “Цагдаагийн эргүүлийн машин” худалдан авах ажлын барааг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын түвшинд хүлээн авахыг комиссын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121404